



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/41

Хажуу шинэ үс

Эхо аппарат хүлээн авах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 5 бүлгийн 74 дүгээр зүйлийн 2 дахь заалт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар, "Мед буян ХХК-тай байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4D/5D өнгөт эхо аппарат суурилуулах ажлыг шинээр хийж гүйцэтгэх ажил үйлчилгээнд хяналт тавих илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийг хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: П.Цэцэгмаа \Эрүүл мэндийн төвийн эх баригч бага эмч\
Гишүүд: Н.Өлзийтогтох \Тамгын газрын дарга\
Б.Батцэнгэл \Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч\
М.Саруултамир \Эрүүл мэндийн төвийн нярав\
Ц.Одгэрэл \Мед буян ХХК-ийн инженер\

2. "Мед буян ХХК-тай хүлээн авах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн нэр төрөл, хэмжих нэгж, тоо ширхэг, хүчин чадал бүрээр нь акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөд бүртгэн авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН